

БАТЛАВ:

БАТЛАВ:

СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ
ЗАХИРАЛ
..... /...../
/Б.БАЙГАЛМАА/

**Нийслэлийн Соёлын Төв Өргөөний
“Их танхим”-ыг ашиглуулах түрээсийн гэрээ**

20... оны ... дугаар
сарын ... -ний өдөр

дугаар

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Нэг талаас Нийслэлийн Соёлын Төв өргөөний захиргааг төлөөлж, ажилтайовогтой, Нөгөө талаас
.....
төлөөлж,
ажилтай овогтой нар **их танхимд** 20.... оны
–р сарын-ны өдрөөс-р сарын-ний өдрийн цаг
хүртэл тоглолт,
арга хэмжээ зохион байгуулахаар энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Гэрээний зорилго нь их танхимд зохион байгуулах арга хэмжээнд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.3. Гэрээ нь Монгол Улсын Иргэний хууль, Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгжийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, НИТХТ-ийн тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ыг баримтлан хийгдсэн тул оролцогч талууд дагаж мөрдөх эрх актын үндэслэл болно.
- 1.4. Тайз засалт-р сарын-ны өдрийнцагаас-р сарын-ны өдрийн цаг байна.
- 1.5. Захиалагчийн тал үзвэрийн тасалбарын 10-р эгнээний 1-24 дүгээр суудлуудыг, Түрээслүүлэгчийн тал 10 дугаар эгнээний 25-49 дүгээр суудлуудыг тус тус авна.
 - 1.6. Тасалбарын үнэ: Партер төгрөг
Бельэтаж төгрөг

Хоёр. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

- 2.1. Түрээслүүлэгч дараах эрх эдэлнэ.
 - 2.1.1. Их танхим ашиглуулсны хөлсийг нийт орлогын хувиар тооцоолж авна. Байр талбай ашигласны хөлсийг арга хэмжээ эхлэхээс 3 хоногийн өмнө урьдчилан ороогүй тохиолдолд тайз ашиглуулахгүй байх эрх эдэлнэ.
- 2.2. Түрээслүүлэгч дараах үүрэг хүлээнэ.

- 2.2.1. Их танхимд зохион байгуулж буй арга хэмжээнд шаардлагатай өрөө тасалгааг тавилгын хамт жагсаалтаар хүлээлгэж өгөх ба ажил дууссаны дараа хүлээн авна.
- 2.2.2. Их танхим, өрөө тасалгаа, техник хэрэгслийг түрээслэгч /захиалагч/-ийн үйл ажиллагааг явуулах хэвийн нөхцлийг хангана.
- 2.2.3. Үйл ажиллагаа явуулах тайз, гэрлийн найдвартай бэлэн байдлыг хангаж, зөвхөн өөрийн байгууллагын дууны болон гэрэлтүүлгийн техникчээ ажиллуулна. Захиалагч талын техникч ажиллаж байх хугацаанд техник, тоног төхөөрөмжийн эвдэрч, гэмтсэн, арга хэмжээ саатсан тохиолдолд хохирлыг захиалагч тал бүрэн хариуцна.
- 2.2.4. Түрээслэгч /захиалагч/-ийн зохион байгуулж буй арга хэмжээ нь гэрээний нөхцлийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавина.
- 2.2.5. Түрээслэгч /захиалагч/-ийн үйл ажиллагааны буруугаас байгууллагад учирсан хохирлыг арилгуулна.
- 2.2.6. Үдэшлэг, уулзалт, урлагийн тоглолт зэрэг орлогын бус арга хэмжээний үйлчилгээний хөлсийг **нэг** цагт төгрөгөөр, хурал зөвлөлгөөнийг **нэг** цагт төгрөгөөр тус тус тооцон нийт цагийн хөлсөнд төгрөг авна. Цагийн хөлсийг үйл ажиллагааны чиглэлээр бүтээгдэхүүний өртөгтэй уялдуулан тооцож, жагсаалтаар баталсан байна. Цаг хэтэрсэн тохиолдолд төлбөрийг нэмж авна.
- 2.2.7. Тухайн үзвэр, тоглолтонд албан ёсоор оролцох хүмүүсийн нэрсийн жагсаалтыг тоглолт болохоос 2-оос доошгүй хоногийн өмнө Соёлын Төв Өргөөний захиргаанд өгч, гэрээнд хавсаргана.

Гурав. Түрээслэгч /захиалагч/-ийн эрх, үүрэг

- 3.1. Түрээслэгч нь үйл ажиллагаа явуулахдаа Монгол Улсын хууль тогтоомж болон дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.
- 3.2. Тайзны болон өрөө тасалгааны техник хэрэгсэл, эд хогшлыг хайр гамтай эдэлж, ажлаа дуусмагц жагсаалтаар хүлээлгэж өгнө.
- 3.3. Зохион байгуулагдаж буй арга хэмжээнд зориулсан засал чимэглэл, зар суратлчилгааг өөрийн зардлаар хийнэ.
- 3.4. Тайзан дээр зохион байгуулагдаж буй арга хэмжээнд оролцогчид нь хөдөлмөр хамгаалалтын болон галын аюулгүй ажиллагааны байдлын тухай хууль, дүрмийг дагаж биелүүлнэ.
- 3.5. Түрээслэгчийн үйл ажиллагааны буруугаас болоод барилга байгууламж, техник хэрэгсэл, эд хөрөнгөнд хохирол учруулбал түрээслэгч хариуцна.
- 3.6. Зохион байгуулагдаж буй арга хэмжээний тасалбар /урилга, билет/-ыг нийт суудлын тооноос хэтрүүлэхгүй ба үзвэрийн тасалбарт Соёлын Төв Өргөөний билетийн кассын тэмдэг даруулсан байна. Үзвэрийн тасалбарт Соёлын Төв Өргөөний билетийн кассын тэмдэг дарагдаагүй бол тус тасалбарыг хүчингүйд тооцно.
- 3.7. Түрээслэгч нь тоглолт, арга хэмжээний үед өөрийн ажилчдыг үзэгчид оруулах төв болон ажилчид ордог хаалганд хяналт тавиулахаар ажиллуулж болно.

Дөрөв.Төлбөр тооцоо, хариуцлага

- 4.1.** Талбай ашигласны цагийн хөлсийг арга хэмжээ эхлэхээс 3 хоногийн өмнө, билетийн тооцоог холбогдох баримтуудыг үндэслэн хийж, орлогын шимтгэлийг өдөр тутам хийж, төлбөрийг төлнө.
- 4.2.** Гэрээнд өөрөөр заагаагүй бол байрны цагийн хөлс, орлогын шимтгэлийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг арга хэмжээг зогсоох арга хэмжээ авах буюу шаардлагатай бол шимтгэл төлүүлэх асуудлыг хамтран шийдвэрлэнэ.
- 4.3.** Түрээслэгч графикт оруулсан тоглолт, арга хэмжээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр явуулаагүй нөхцөлд төлөвлөсөн хугацаагаар тооцож шимтгэл төлүүлнэ.
- 4.4.** Тайз, гэрлийн ажилчидтай зүй бусаар харьцах, тайз, бэлтгэлийн өрөөнд тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зөрчил гаргасан тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авна.
- 4.5.** Тоглолт эхлэхээс өмнө нэг цагийн өмнө дууны операторт MD,CD, кассет бичлэгээ шалгаж, өгсөн байна. Тоглолтын хугацаанд гарсан техникийн саатал, доголдлыг түрээслүүлэгч хариуцахгүй.
- 4.6.** Тоглолтын болон сургуулилтын цагийг гэрээнд заасны дагуу чанд баримтлана.

Тав. Давагдашгүй хүчин зүйл

- 5.1.** Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 5.2.** Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог мэргэжлийн байгууллагаар гаргуулна.

Зургаа. Бусад асуудал

- 6.1.** Гэрээнд оролцогч талуудын аль нэг нь нөгөө талын өмнөөс гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй.
- 6.2.** Түрээслэгч нь Монгол Улсын хууль, тогтоомжоор тогтоосон журмыг зөрчсөн буюу гэрээний нөхцлөөс гадуур зориулалтын бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 6.3.** Гэрээнд оролцогч талуудын аль нэг нь гэрээнд заагдсан үйл ажиллагааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зохион байгуулах бололцоогүй болсон тохиолдолд нөгөө талдаа ажлын 7 хоногоос доошгүй хугацааны өмнө мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ.
- 6.4.** Гэрээнд оролцогч талуудын түрээсийн гэрээний үүргийн биелэлттэй холбоотой гарсан маргааныг хамтран шийдвэрлэх бөгөөд энэ талаар тохиролцоонд хүрээгүй тохиолдолд хууль, хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 6.5.** Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.6.** Түрээслүүлэгчийн харилцах:
Банкны нэр: Нийслэлийн төрийн сан
Дансны дугаар: 200051014
- 6.7.** Түрээслэгчийн харилцах:

Банкны нэр:

Дансны дугаар:

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Түрээслүүлэгчийг төлөөлж

Түрээслэгчийг төлөөлж

Хаяг: Соёлын Төв Өргөөнд
.....ажилтай
.....

Хаяг:
.....ажилтай
..... ОВОГТОЙ.....

ОВОГТОЙ

Утас:

Утас:

Гарын үсэг:
/.....

Гарын үсэг:
/...../

...../

Хянасан: Хуулийн зөвлөх.

.....

ОВОГТОЙ

Утас:

Гарын үсэг:
/.....

...../

